



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

“Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт”
ХХК-ийг татан буулгах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.5 дахь заалт, дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-ийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Компанийг татан буулгах комиссыг томилж, холбогдох ажиллагааг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсанаар Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100967